



Математикийн аварга анги шалгаруулах тэмцээн

5-р анги

1. 240×500 үржвэрийн утгыг олоорой.
A. 240500 B. 120000 C. 12000 D. 12250
2. $9,04 \cdot 10 : 1000 : 0,01$ илэрхийллийн зөв хариуг сонгоорой.
A. 90,4 B. 0,904 C. 0,0904 D. 9,04 E. 904
3. Нэг нэмэгдэхүүнийг 108-аар хорогдуулав. Нийлбэрийг хэвээр байлгахын тулд нөгөө нэмэгдэхүүнийг яаж өөрчлөх вэ?
A. 108-аар хорогдуулна. B. 216-аар нэмэгдүүлнэ. C. 108-аар нэмэгдүүлнэ. D. 216-аар хорогдуулна E. 54-өөр хорогдуулна
4. Квадратын периметр нь 28 см бол талбайг олоорой.
A. 49 кв.см B. 784 кв.см C. 196 кв.см
5. 725892 тоог мянгаар тоймлоорой.
A. 725000 B. 726000 C. 725900 D. 730000 E. 725800
6. 2,035 бутархайг энгийн бутархай хэлбэртэй болгоорой.
A. $2\frac{35}{1000}$ B. $2\frac{35}{100}$ C. $2\frac{35}{500}$ D. $2\frac{15}{500}$
7. Эзлэхүүнийг хэмжих нэгж аль нь вэ?
A. метр B. кв.см C. кг D. дм E. куб.см
8. 56 м-ийг километрээр илэрхийлээрэй.
A. 56 км B. 5,6 км C. 0,56 км D. 0,056 км E. 560 км
9. 2,75 литрийг куб.см-д шилжүүлээрэй.
A. 27500куб.см B. 2750 куб.см C. 275куб.см D. 275000куб.см E. 2750000куб.см
10. Мэдэгдэхгүй байгаа өнцгийн хэмжээг олоорой.




- A. 155° B. 65° C. 75° D. 90°
11. Ангид байгаа 39 сурагчийн 24 нь хөвгүүд, 15 нь охид байв. Охидын тоог бүх сурагчийн тоонд харьцуулсан харьцааг олоорой.
A. $39 : 15$ B. $39 : 24$ C. $15 : 39$ D. $24 : 39$
12. Автомашин 1008 км замыг 14 цагт туулдаг бол энэ хурдаар автомашин 7 цаг явах замын хэмжээг олоорой.
A. 144 км B. 72 км C. 5040 км D. 504 км
13. Тоон шулуун дээрх К цэгт харгалзах тоог олоорой.



- A. 9 B. 10 C. 5 D. 15
14. Зүй тогтлыг ажиглаад, х-ийн оронд тохирох тоог олоорой. 832, 416, 208, х, 52, 26, 13
A. 156 B. 845 C. 819 D. 104

15. Дараах дэлгээсээр хайрцаг хийвэл аль биет үүсэх вэ?



- A. пирамид B. куб C. цилиндр D. гурвалжин призм

16. Эгч 240 000 төгрөгийн $\frac{1}{3}$ хэсгээр гар утас, үлдсэн мөнгөөрөө хүнсний зүйл авав. Эгч хэдэн төгрөгөөр хүнсний зүйл авсан бэ?

- A. 40 000 B. 240 000 C. 160 000 D. 80 000

17. Үйлдлийг гүйцэтгээрэй. $45,78 \cdot 100 : 1000 : 0,1 =$

- A. 4,578 B. 45,78 C. 457,8 D. 0,4578 E. 4578

18. Нэг үржигдэхүүнийг 4 дахин ихэсгэж нөгөө үржигдэхүүнийг 2 дахин багасгав. Үржвэр яаж өөрчлөгдөх вэ?

- A. 8 дахин нэмэгдэнэ. B. 8 дахин багасна. C. 2 дахин багасна. D. 2 дахин ихэснэ. E. 16 дахин ихэснэ.

19. 3 ба 0 цифрээр дөрвөн оронтой тоо хэчнээнийг бичиж болох вэ?

- A. 2 B. 6 C. 4 D. 8 E. 16

20. 8 байлдагчийг хоёр хоёроор нь манаанд гаргана. Хэдэн боломжтой вэ?

- A. 64 B. 72 C. 28 D. 32 E. 36